

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн
А/23.5 дүгээр тушаалын тавдугаар хавсралт



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ГЭР, НЭГ АЙЛ ӨРХИЙН ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ШАЛГАН ЗААВАРЛАХ ХУУДАС

2020 оны ... сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот аймаг сум
..... баг хэсэг –р хороо, гудамжны тоотод оршин суудаг
..... овогтой –ны гэр, байшин
/доогуур зурах/-д галын аюулгүй байдлын үзлэг хийж, зөрчлийг арилгуулах
заавар өгсөн хуудас. Ам бүлийн тоо:, насанд хүрсэн /өндөр настан/ хүн:
....., хүүхэд:, бусад:, үзлэгийн явцад нийт хэдэн хүн байсан:,

д/д	Хууль, норм, дүрмийн заалт	Хяналт тавих чиглэл	Илэрсэн зөрчил	Арилга -сан зөрчил	Тайл -бар
Галын аюулгүй байдлын тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, заавар, стандартын норм нормативын хэрэгжилт					
1	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2. 16.2.1. дэх заалт	Ахуйн галын аюулгүй байдлыг бүрэн хангаж, холбогдох хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн шаардлагыг сахин биелүүлсэн эсэх;			
2	Хог хаягдлын тухай хуулийн 10.3.3, 10.3.4 дэх заалт	Хог хаягдлыг ил задгай шатаах, Гэрийн болон нам даралтын зууханд нийлэг материалтай хог хаягдлыг шатаахыг хориглоно.			
3	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 6.5.	Гэр хорооллын гудамж, айл өрх нь хороо, багийн хэмжээнд жигдэрсэн харагдахуйц хаягжилттай байх бөгөөд гудамж хооронд галын автомашин чөлөөтэй зорчих, байрлах зайтай байна.	Зөрчилтэй гудамжийн хаяг:		
4	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 6.6.	Мухар гудамж зайлшгүй гаргасан тохиолдолд төгсгөлдөө галын автомашин чөлөөтэй эргэх 15x15м талбай			

		гаргана.			
5	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 6.7.	Гэр хороололд шатах шингэн, хий ашигласан үйлдвэрлэл явуулахыг хориглоно.			
6	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 6.8.	Гэр байшин, гэр хоорондын зай 5м-ээс дээш байна.			
7	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 6.9, Пийшин зуухыг галлах үед галын аюулгүй байдлыг хангах. Халаалт агаар сэлгэлт ба кондиционер 6-р зүйл	Пийшин зуухны амны дор 700x500 мм-ийн хэмжээтэй металл хуудсыг урт талыг нь пийшинг дагуулан байрлуулна.			
		Шатах материалаар хийгдсэн хана, хамар хана зуухнаас 500мм зайд, яндангийн хананаас 380мм зайд тусгаарлана. Тусгаарлалт нь хучилт, дээврийн зузаанаас 70 мм илүү байна.			
		Галлах амнаас эсрэг талын хана хүртэлх зай 1250мм-ээс багагүй байна.			
8	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 6.10.	Галлагааны улирлын өмнө зуух, пийшин, уурын зуух зэрэг дулаан үүсгэгч хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, илэрсэн гэмтлийг арилгасан байна.			
9	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 6.12.	Гэр хорооллын айл, өрх үнс нурмаа ухаж бэлтгэсэн хаалт, таглаа бүхий нүхэнд асгана.			
10	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 6.14.	Өрх бүр гал гарсан үед ашиглах багаж хэрэгсэлтэй байна. (гал унтраагуур, хүрз, хувин, дэгээ, эсгий, цохиур г.м)			
11	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 4.3.	Цахилгаан дамжуулах агаарын шугамыг шатдаг бараа материал, эд зүйл, задгай агуулахын дээгүүр татах, эсхүл шатдаг материалаар хийгдсэн дээвэр дээр дамжуулан татахыг хориглоно.			
12	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 4.11.1.	Дамжуулагчийн тусгаарлагч нь шалбарч гэмтсэн, ашиглалтын явцад тусгаарлах чанараа алдсан шугам, дамжуулагч утсыг ашиглахыг хориглоно.			
13	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 4.11.2	Хүчдэлд тохироогүй чанарын шаардлага хангахгүй гал хамгаалагч хэрэглэхийг хориглоно.			
14	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 4.11.4	Барилга байгууламжийг халаах зорилгоор стандарт бус цахилгаан зуух, бусад			

		төхөөрөмж ашиглахыг хориглоно.			
15	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 4.11.7.	Цахилгаан дамжуулах утсыг хадаасаар бэхлэх, хаалганы хавтасны завсараар гаргах, цахилгааны утас, унтраалгаас эд зүйл өлгөхийг хориглоно.			
16	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 4.11.9	Цахилгааны хянах самбар, цахилгаан хөдөлгүүр, асааж унтраах аппаратын дэргэд шатамхай (хялбар авалцан асах) бодис, материал байрлуулах, хураахыг хориглоно.			
17	Хийн хангамж БНБД42-01-04,	Галын аюултай бодис, шатах, тослох, материалыг (шингэрүүлсэн шатдаг хийн түлшээр ажиллах тоног төхөөрөмж) хэрэглэх, тээвэрлэх, хадгалах, ашиглахдаа Хийн аж ахуйн техник ашиглалтын дүрэм, Хийн аж ахуйн аюулгүй ажиллагааны дүрэм, Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн хэрэгжилтийг хангуулах.			

Заавар зөвлөмж өгсөн албан тушаалтан: /..... /

Хянасан: Гал түймрийн улсын хяналтын байцаагч /..... /

Байлцсан иргэн: /гарын үсэг/..... /

БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалтны нэр	Хүлээн зөвшөөрсөн, байлцсан : иргэн
/Овог нэр/	/Овог нэр/
/Гарын үсэг, тэмдэг /	/Гарын үсэг/